

ИНСТИТУТ ВОСТОЧНЫХ РУКОПИСЕЙ РАН  
САНКТ-ПЕТЕРБУРГСКИЙ БЛАГОТВОРИТЕЛЬНЫЙ ОБЩЕСТВЕННЫЙ ФОНД  
«ОБЩЕСТВО БУРЯТСКОЙ КУЛЬТУРЫ АЯ-ГАНГА»

**БУДДИЙСКАЯ КУЛЬТУРА:  
ИСТОРИЯ, ИСТОЧНИКОВЕДЕНИЕ,  
ЯЗЫКОЗНАНИЕ И ИСКУССТВО**

*СЕДЬМЫЕ ДОРЖИЕВСКИЕ ЧТЕНИЯ*  
**БУДДИЗМ И СОВРЕМЕННЫЙ МИР**

**Материалы конференции**

**Улан-Удэ**

**6–8 июля 2016 года**

**Санкт-Петербург  
2018**

## Бичээч цорж Агваандоржийн намтарт холбогдох зарим мэдээ

### (Некоторые сведения, связанные с биографией Агваандоржа, литератора и главы монастырских церемоний)

*В статье приводится ряд интересных обстоятельств, связанных с биографией и деятельностью известного монгольского литератора, одного из образованных людей Монголии Агваандоржа, занимавшего пост главы монастырских церемоний. Автор сравнивает сведения об Агваандорже, содержащиеся в различных источниках XVIII–XIX вв., с информацией в книге «Последовательные краткие жизнеописания учителей Страны снегов», изданной в 1996 г. на тибетском языке в Китае. Эта информация занимает несколько страниц. Автор приходит к выводу, что именно она вызывает наибольшее доверие и может считаться предельно верной.*

**Ключевые слова:** литератор, Агваандорж, Агваанцэрэн, литераторы Их хүрээ, биографии монгольских лам.

Энэхүү өгүүлэлдээ бид БНХАУ-ын Хөхнуурын хэвлэлийн хорооноос 1996 онд хэвлэсэн «Gangs can mkhas dbang rim byon gyi rnam thar mdor bsdus» нэрт номын 485–488 дугаар талд буй бичээч цорж Агваандоржийн товч намтар дахь зарим мэдээнд ажиглалт хийв.

Ажиглаваас дараах хэдэн зүйлийг тодруулах шаардлага бичээч цорж Агваандоржийн намтар судлалд тулгамдсан асуудал болж байна. Үүнд:

1. Бичээч цоржийн нэрийн олон зүйлийг тодруулан тэмдэглэх.
2. Бичээч цоржийн мэндэлсэн болон таалал болсон хугацааг тодруулах.
3. Бичээч цоржийн зохиол бүтээлийн судалгааг эрчимжүүлэх эдгээр болно.

Бичээч цоржийн нэрийн тухай дээрх товч намтарт «цорж Агваандорж нэртийн Лавран дашичилийн гарчиг болон гадаадад хэвлэгдсэн гарчигт цорж Агваанцэрэн хэмээсэн байх боловч, түүний бүрэн зохиолын төгсгөлийн үгэнд Агваандорж гэж байх тул, энд түүний алдарыг Агваандорж хэмээн бичлээ» [8, х. 488] гэжээ. Энд өгүүлэн буй монголын бичгийн мэргэдийн нэг бичээч цорж Агваандорж нь «Да хүрээ цорж», «Хүрээний цорж», «Агваанцэрэн», «Агваандорж», «Агваан» гэж байдагтай үндсэндээ таарч байна. Харин уг товч намтрын гарчигт «Zhabs drung chos rje» гэсэн нь бусад судлаачдын бүтээлд тэмдэглэгдээгүй байна. Түвд хэлний «Zhabs drung» нь монгол хэлнээ «Хутагт, хувилгаан» гэх мэт утгатай юм. Үүнийг бид «Хувилгаан цорж» гэж оноох саналтай байна. Магадгүй тэрээр урт насны авшиг хүртсэн, ид шидийг олсон нэгэн байсан ч байж болох юм.

Түүний намтар, зохиол бүтээлийг өнгөрсөн зууны 60-аад оноос эхлэн дараах эрдэмтэд судалсан байна. Үүнд:

1. Ш. Иштавхай [9],
2. Академич Ц. Дамдинсүрэн [4, х. 19],
3. Номч мэргэн хамба, гавж С. Гомбожав [3],
4. Ш. Бира, О. Сүхбаатар, Х. Гаадан [5],
5. Доктор Л. Хүрэлбаатар,
6. Доктор, проф, гавж Ш. Сонинбаяр [1],
7. Доктор, проф, гавж Т. Булган,
8. Судлаач Р. Бямбаа [2, х. 51],
9. Түүхийн ухааны доктор Л. Чулуунбаатар-ын [7] судалгааг дурдаж болно.

Гэвч, өнөө хэр нь түүний намтар судлал, зохиолын судалгаанд хүлээгдэж буй болон тодруулаагүй мэдээ баримт байсаар байна.

Түүнийг аль нутаг хошууны хүн болох талаар гавж, доктор, проф Ш. Сонинбаяр *«Бичээч цорж Агваандорж нь Хэнтий аймгийн Баянмөнх сумийн “Хэрээн хөхөл” нутгийн хүн юм»* [1] гэж мэдээлсэн байна. Бидэнд буй товч намтарт энэ тухай тодорхой мэдээ байхгүй байна.

Дараа нь дээрх товч намтарт тэмдэглэснээр *«...халх жэвзүндамба Лувсанданбийжанцанд ном айлтгаж, амсахын орны ёсыг үзүүлснээс жишвэл нийтийн тооллын XVIII зууны эхэн төдийд лагшин мэндэлсэн мөн»* [8, х. 486] гэжээ. Энэ талаар тухайлбал, С. Гомбожав *«Агваандорж, Их хүрээний цорж. XVIII зууны үеийн хүмүүн. Зохиол нь арван дөрвөн боть, судар, тарнийн тайлбар ба утга зохиолын онол зэрэг. Их хүрээнд бүрэн бартай»* [6, х. 33] гэх мэт судлаачид ихэнхдээ түүнийг XVIII зууны үеийн хүн гэжээ. *«Халх жэвзүндамба Лувсанданбийжанцан»* нь монголын анхдугаар богд, Өндөр гэгээн Занабазар мөн. *«Ном айлтгаж, амсахын орны ёсыг үзүүлснээс»* гэдэг нь бичээч цорж нь нэгдүгээрт багадаа Өндөр гэгээнд шавь орж байсан, хоёрдугаарт он удаан жилээр ном заалгаж чадаагүй гэсэн утга тус тус агуулагдаж байна.

Товч намтарт түүний нас барсан талаар *«арван гуравдугаар жарны ус хулгана (1792) жил нас барсан юм болов уу»* гэснээс дараах таамаглалыг бид дэвшүүлж байна. *«Тэрээр нас сүүдэр 80 илүү насалсан...»* [8, х. 486] болов уу гэх мэдээнд үндэслэн, түүнийг 81 сүүдэртэй таалал болсон гэж үзвэл, 1711 онд тэрээр мэндэлсэн болно. Энэ нь Өндөр гэгээнийг таалал болохоос 12 жилийн өмнө, түүнийг 76 нас сүүдэртэй байх үе таарна. Мөн бичээч цорж Агваандорж нь 5 настайдаа анх ном сонссон гэж үзвэл, Өндөр гэгээнийг 81 нас сүүдэртэй байхад шавь орж, ном сонссон болж таарна. Энэ мэт таамаглал дэвшүүлэхийн учир нь түүний мэндэлсэн оны тухай харилцан адилгүй хэд хэдэн мэдээ байна. Судлаач Р. Бямбаа 2004 онд хэвлүүлсэн *«Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл»* (II боть, УБ, 2004)-дээ бичээч цорж Агваандоржийн барын зургийг хэвлүүлсний

доод талд ташуу хаалтад, бичээч цоржийн мэндэлсэн болон таалал болсон оныг 1785–1849 гэжээ. Судлаач Р. Бямбаа ямар сурвалжид үндэслэн, түүний мэндэлсэн оныг ийнхүү тогтоосон нь сонирхолтой байна.

Товч намтарт буй нэгэн мэдээг энд сийрүүлэн тэмдэглэе. Тэнд хэзээ таалал болсон он хугацаа тодорхойгүй болохыг дурдаад *«бүрэн зохиолын ХА боть (КНА)-ийн 11 дэх ном болох “Ялгуулсан хийгээд Ялгуулсаны хөвгүүд дор мөрийн эрдмийн олсон ёсны үүднээс магтсан хорин бүлэгт” зохиолыг туурвиснаас 60 жил болох цагт, сэрэмжит жилд зарлигийг бард бүтнээр гаргасан»* [8, х. 487] гэж мэдээлсэн байна. Улмаар эмхэтгэгч «сэрэмжит» гэсэн нь алдаа болохыг тэмдэглээд, XIV жарны Сэрэмжгүй хэмээх усан үхэр жил зохиолыг бүрэн бард гаргасан гэж үзжээ. Тэр нь нийтийн тооллын 1853 он болно. Үүнээс 60 жилийг хасвал, 1793 он болно. Товч намтарт буй дээрх мэдээнд үндэслэвэл, 1793 онд буюу бидний таамаглаж байгаагаар бол 82 настайдаа уг номыг зохиосон болж таарна. Хэрэв судлаач Р. Бямбаагийн тэмдэглэснээр бол энэхүү номыг тэрээр 8 настайдаа туурвисан болно.

Мөн Ж. Ерөөлт, Л. Чулуунбаатар нарын зэрэг ихэнх судлаачид түүнийг XVIII–XIX зууны үеийн хүн гэж тэмдэглэсэн байна. Энэ тухай товч намтарт *«арван гуравдугаар жарны усан хулгана жил нас барсан»* болов уу гэж тэмдэглэсэн байна. Тэр усан хулгана нь нийтийн тооллын 1792 он болно. Үүнд үндэслэвэл, тэрээр XIX зуунд амьдарч байгаагүй болно. Хэрэв, судлаач Р. Бямбаагийн тэмдэглэснээр тэрээр 1849 онд таалал болсон бол халхын гурван дүрийн биш, зургаадугаар дүрийн богд Жэвзүндамбыг монголд залрахын урд жил таалал болсон болно. Бас эндээс товч намтарт *«...гурван богдын үеийг дамжсан нь харагдаж байна...»* гэж юунд үндэслэн бичив гэдэг асуулт гарч таарна. Энэ мэтээр ажиглавал, товч намтар болон зарим судлаачдын барин тавин тодорхой тэмдэглэсэн зарим мэдээ баримтад шууд итгэх боломжгүй, нарийн сайн нягтлан үзэх зайлшгүй шаардлага бий болж байгаа юм. Тухайлбал дээрх товч намтарт *«түүний санваар айлтгасан орон хийгээд номын гол багш Агваанхайдав, Агваанлодой тэргүүтэн мөн»* гэх мэдээний мөрөөр, түүний мэндэлсэн оныг мөшгих боломжтой юм. Түүний гол багш нь хэмээсэн Агваанхайдав нь бичгийн мэргэдийн дунд «Жидорын хамба лам» гэж алдаршсан нэгэн мөн. Эндээс үзэхэд, Агваанхайдав гэх мэт эдүгээ намтар нь тодорхой түүхэн хүмүүстэй зэрэгцүүлэн судлаваас, бичээч цорж Агваандоржийн намтарт холбогдох мэдээг тодруулах бүрэн боломжтой юм.

Энэхүү өгүүллээ бичээч цоржийн зохиол бүтээлд холбогдох зарим мэдээгээр төгсгөе. Ер нь ихэнх судлаачид түүнийг 14 боть зохиолтой гэж үзсэн байна. Харин судлаач Р. Бямбаагийн сүүл үеийн судалгаанаас үзэхэд, бичээч цоржийн зохиол бүтээлийн судалгаанд ахиц гарч, түүний бүрэн зохиолд ороогүй 35 зохиолыг тэмдэглэсэн байна. Судлаач Р. Бямбаагийн тэмдэглэснээр бичээч цоржийн бүрэн зохиолд бүртгэлтэй 352 ном байдаг бөгөөд одоогоор нийт 387 ширхэг ном болсон байна. Хэдийгээр бичээч цорж Агваандоржийн намтар тодорхойгүй боловч, түүний зохиол бүтээлийн

судалгааг нарийвчлан хийх боломжтой бөгөөд эл төрлийн судалгаагаар түүний намтарт холбогдох бусад шинэ шинэ мэдээ баримт гарч ирэх бүрэн боломжтой гэж бид үзэж байна.

Дүгнэлт:

1) Бичээч цорж Агваандоржийн намтар судлалыг XVIII–XIX зууны бичгийн мэргэдийн намтар, Их хүрээний түүхтэй зэрэгцүүлэн судалж, тодруулах боломжтой.

2) Бичээч цорж Агваандоржийн зохиол бүтээлийг бүртгэн мэдээлэх биш, дараагийн шат буюу тухайн судлагдахууны гол аньс утгын төвшинд судлах нь зүйтэй байна.

3) Бичээч цорж Агваандоржийн намтарт холбогдох БНХАУ-ын Хөхнуурын хэвлэлийн хорооноос 1996 онд хэвлэсэн «Gangs can mkhas dbang rim byon gyi rnam thar mdor bsdus» нэрт номын мэдээг нягтлан үзэж, шинжлэх, үнэлгээ дүгнэлт өгөх нь зүйтэй байна.

## Ном зүй

1. «Билгийн мэлмий» сонин, 2007 оны, IX сар, 6-р нүүр.
2. Бямбаа Р. Буддын «Учир шалтгааны ухаан» буюу «Шалгадаг ухаан» // Лавайн эгшиг, № 1. — Улаанбаатар, 2000.
3. Гомбожав С. Монголчуудын Түвд хэлээр зохиосон зохиолын зүйл. — Улаанбаатар: Соёмбо Принтинг, 2005. — 60 х.
4. Дамдинсүрэн Ц. Дандины «Зохист аялгууны толь» ба түүний тайлбаруудын тухай товч мэдээ // Монголын уран зохиолын харилцаа холбооны асуудалд (Өгүүллийн эмхтгэл). — Улаанбаатар, 1987. — Х. 6–21.
5. Дандины Зохист аялгууны толь. — Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн Хэвлэх Үйлдвэр, 1982. — 195 х. (Corpus Scriptorum Mongolorum, vol. 20).
6. Олон улсын эрдэмтний анхдугаар их хурал = The First International Congress of Mongolists. Боть 1 / эмхэтгэгч Бира Ш., Пүрэвжав Э. — Улаанбаатар: Бемби сан, 2009. — 476 х.
7. Чулуунбаатар Л. Сэцэн хан аймгийн Гүндгаварлан хийдийн түүхэн тойм. — Улаанбаатар, 2010.
8. Gangs can mkhas dbang rim byon gyi rnam thar mdor bsdus (Цастын мэргэдийн эрхт дараалал ын товч хураангуй намтар). I дэвтэр / эмхэтгэгч Миняггомбо. — Хөх нуурын хэвлэлийн хороо, 1996.
9. бKa’-rtsom gnang-pa’i khal-kha’i bla-ma rnam-skyi mtshan-tho bzhu-gs-so (Ном зохиолоо туурвисан халхын лам нарын бүртгэл оршвой). — Улаанбаатар, 1958.